



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/597

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мянганы босоо тэнхлэгийн авто замтай сумын төвийг холбох 0.95 км цементэн хучилттай авто замын барилгын ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Д.Энхболд – Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

И.Гантогтох – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах, цагдаагийн хошууч

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын авто замын улсын байцаагч

Б.Сонинтуяа – Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Ч.Улаанхүү – Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Ө.Хишигтогтох – Мянгад сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Ц.Цэцэгмаа – Мянгад сумын газрын даамал

С.Батдорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2.Мянганы босоо тэнхлэгийн авто замтай сумын төвийг холбох 0.95 км цементэн хучилттай авто замын барилгын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Энхболд/ - д даалгасугай.

3.Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН